БАТЛАВ.

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХДЭЛГЭР

2023 оны ...04... дүгээр сарын ...14... ны өдөр

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ТӨВД НИЙТИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР БАЙГУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Нэр төрөл	Хүчин чадал, үзүүлэлт, тоо хэмжээ
1	Төсөл хэрэгжүүлэх үндэслэл	Эрдэнэдалай сумын төвд наадмын талбай, спорт заалны гадна талд нийтийн бие засах газар байгуулах. / 1 нийтийн бие засах газрыг шинээр байгуулах, сургуулийн гадна талд байгаа ариун цэврийн байгууламжийг засаж тохижуулах/
2	Захиалагч байгууллага	Засаг даргын тамгын газар
3	Байгууламж байгуулах байршил	Эрдэнэдалай сум 7-р баг спорт заалны зүүн талд 1, сургуулийн гадна талд байгаа нийтийн бие засах байгууламжийг засаж тохижуулан наадмын талбайн урд талд байршуулах
4	Ерөнхий байдал, загвар	Өнгө үзэмж, загвар орчин үеийн шийдэлтэй, өвлийн улиралд ашиглаж болохуйц дулаалсан байх.
5	Нийт кв.м	36 м кв / 12:3 /
6	Шинээр байгуулах байгууламжийн Нэмэлт хэрэгслүүд	Суултуур / эм / 4ш
		Суултуур /эр / 2 ш
		Хөтөвч /эр / 2 ш
		ХБИ-суултуур 1 ш / Хөгжлийн бэрхшээлтэй иргэн/
		Угаалтуур 3 ш
		Угаалтуур / хүүхэд/ 1 ш
		Гар хатаагч 2 ш
		Контэйнер / 5,5 тн / 1 ш
		Бүргэд хаалга 1 ш
		Вакум цонх / 2:1,5 м / 2 ш
		Агааржуулагч хоолой /суултуур болгонд/
		Хогийн сав 7 ш
		Толь / 50:60 см / 4 ш
		Нойлын цаас тогтоогч 7 ш
		Эрэгтэй эмэгтэй нойлын хаяг 7 ш
		Тасалгааны материал / бат бөх, цэвэр үзэмж сайтай байх/- 2:1,5 м талбайтай үйлчлэгчийн өрөө байгуулах
		Гадна хаяг 1
		Гэрэлтүүлэг / цахилгаан бага зарцуулах лед гэрэл төлөвлөх/
		Бойлуур / 50 л / - 1 ш

		Нөөцийн сав /1 тн/-1 ш
		Вакум нацосс - 1 ш
		Доторлогооны материал / хана, тааз, шал, дулаалгын материал нь зөөвөрлөхед тохиромжтой, бат бөх, цэвэр үзэмж сайтай байх/
		Сантехникийн холболтууд: - Сайн чанарын материалаар хийгдсэн, эвдрэл гэмтэлгүй байх - Дотор холболтууд бүрэн хийгдсэн байх - Ginde бренд буюу түүнтэй дүйцэхүйц байх / гадна цэвэр усны эх үүсвэр наадмын талбайдах нь 100 м-ээс татах, спорт заалны зүүн талд байршуулах нойл зөөвөрөөр шийдэх ба стандартын дагуу сувагжилтанд хийх/
		Цахилгаан: - Сүүлийн үеийн баталгаат тоолууртай байх, тоолууraас бие засах газрын бүх цахилгааныг холбосон хувиарлах самбартай, тус бүрдээ пускательтай байх
		Халаалт дулаан: Төвийн төвлөрсөн цэвэр, бохир, дулааны шугамд холбох, сантехникийн холболтуудыг бүрэн шийдсэн байх
		Бохирын хоолой, цооног болон худгийг нэмэлтээр шийдвэл давуу тал болно.
7	Засварлаж, тохижуулах нийтийн бие засах байгууламжийн нэмэлт хэрэгслүүд /40 тн контейнэр/	- Суултуур-4 ш, Угаалтуур 1 ш, тасалгаа 1 бүтэн, бойлуур 1 ш, Вакум нацосс- 1 ш, - Агааржуулалтыг бүрэн шийдэх, - Цахилгаан болон сантехникийн холболтуудыг бүрэн хийх, - Халаалтыг цахилгаан халаалтаар шийдэх, - Бохирын хоолой, цооног болон худгийг холболтыг бүрэн хийх
8	Нэмэлт заалт	Наадмын талбайн урд шинээр нийтийн бие засах газрыг түр байршуулж, буцааж сумын төвд зөөвөрлөж байршуулах, Сургуулийн урд байрлалтай ариун цэврийн байгууламжийг нүүлгэн шилжүүлж спорт заалны гадна байрлуулах зардал орно.



Зураг 2. Эрэгтэй хүнд зориулсан ариун цэврийн өрөөний төлөвлөлт. (Жишээ зураг)



Зураг 3. Эмэгтэй хүнд зориулсан ариун цэврийн өрөөний төлөвлөлт. (Жишээ зураг)

АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНИЙ ТОНОГЛОЛ, ХЭРЭГСЭЛ

Олон нийтийн барилга доторх ариун цэврийн өрөөний тоноглолыг дараах байдлаар ангилна.

- Хүйс : Эрэгтэй, эмэгтэй / эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөнд суултууртай хамт угаалын тосгуур суурилуулах шаардлагатай /
- Нас : Хүүхдийн / сургуулийн өмнөх болон бага дунд сургуулийн насны/ болон насанд хүрэгчдэд зориулсан
- Тоног төхөөрөмж: Ариун цэврийн өрөө – тосгуур, суултуур, хөтөвч, ариун цэврийн цаас тогтоогч, хувцасны өлгүүр, хогийн сав, толь, бариул, түргэн тусламжийн хонх, хатаагч
- Ус хангамж, ариун цэврийн хэрэгслийн холболт: Ил, далд, холимог холболттой,
- Ус зайлуулах хоолойн байршил: шалны дагуу, хананд, доод давхрын таазны дор

АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Нийтийн ариун цэврийн өрөө нь ариун цэврийн шаардага хангасан, өрөөний урт, өргөн, талбайн хэмжээ тавих шаардлага, стандартын дагуу дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:



ег 4. Бие засах кабины нүүр тал (Жишээ зураг) *Зураг 5. Бие засах кабины хажуу тал (Жишээ зураг)*

- Ариун цэврийн өрөөний кабины хаалга нь өнгө үзэмж сайтай, гэмтэлгүй байвал зохино.

- Ариун цэврийн өрөөний таних тэмдгийг хавсралт 1-д заасны дагуу хийнэ. Ариун цэврийн өрөөний шал нь хальтардаггүй материлаар хийгдсэн, нэг түвшинд байна.

ХҮЛЭЭЖ АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нийтийн бие засах газрын стандарт шаардлага хангаж байгаа эсэхийг дараах хүлээн авах шалгуур үзүүлэлтийн дагуу хянан шалгаж хүлээж авна. Үүнд :

№	Шалгуур үзүүлэлт
1	Ариун цэврийн өрөө нь өнгө үзэмж сайтай, эвдрэл гэмтэлгүй, ариун цэврийн шаардлага хангасан эсэх
2	Ариун цэврийн өрөөний стандарт тоо хэмжээ тохирч байгаа эсэх
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх бололцоог хангасан эсэх
4	Иж бүрэн тоноглогдсон эсэх
5	Ус хангамж, ариутгах татуургын систем нь стандартад нийцэж байгаа эсэх
6	Өрөөний температур зохих хэмжээндээ хүрч байгаа эсэх
7	Халаалт агааржуулалтын систем хэвийн ажиллаж байгаа эсэх
8	Гэрэлтүүлэг хангадттай байгаа эсэх

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ТӨВД БАЙРШУУЛАХ НИЙТИЙН БИЕ ЗАСАХ ГАЗРЫН БАЙРШИЛ

1. Спорт заалны зүүн талд

1. Наадмын талбайн урд талд / 100 жилийн ойн баяр наадмын дараа зөөвөрлөж Төрийн банкны урд талд байршуулах